



**ЗАВХАН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 01 сарын 16 өдөр

Дугаар А/13

Улиастай

Тусламж үзүүлэх тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Амьдралын зайлшгүй нөхцөл байдлаа дурдаж тусламж хүссэн Улиастай сумын Чигэстэй багийн ахмад настан Гомбын Даваасүрэнд 200.000 (хоёр зуун мянга) төгрөгийн тусламж үзүүлсүгэй.

2. Тусламжид шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Г.Мягмарсүрэн)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Д.Бадамсүрэн)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Т.ӨНӨРБАЯР